



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/511

Улаанбаатар хот

Комисс томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Холбоо, навигаци, ажиглалтын албаны хавсралтад дурдсан сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Ё.Эрдэнэбат	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	В.Эрдэнэчимэг	Холбоо, навигаци, ажиглалтын албаны захиргааны ахлах мэргэжилтэн
Гишүүд:	М.Эрдэнэсүх	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газрын техникийн бодлого, хариуцсан мэргэжилтэн
	Д.Баяртогтох	Холбоо, навигаци, ажиглалтын албаны дарга
	Х.Баттулга	Холбоо, навигаци, ажиглалтын албаны ерөнхий инженер
	Б.Гэсэрбадам	Захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн мэргэжилтэн
	Д.Отгонхүү	Монголын аэронавигацийн инженер техникийн ажилтнуудын холбооны тэргүүн

2. Сонгон шалгаруулалтыг “Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулахыг комиссын дарга /Ё.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.


3. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг зохих журмын дагуу зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ч.Нямсүрэн/-т даалгасугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 11 дугаар сарын 13-ны өдрийн
А/511 дугаар тушаалын хавсралт



Сул ажлын байрны жагсаалт

№	Албан тушаал	Мэргэжил	Ажлын байршил
1	Холбооны хэсгийн мэдээллийн технологийн инженер	Сүлжээний хамгаалалтын инженер	Улаанбаатар хот, Буянт-Ухаа дахь Нислэг хөдөлгөөн удирдлагын төвд ажиллах
2	Холбооны хэсгийн мэдээллийн технологийн ээлжийн инженер	Мэдээллийн технологийн сүлжээний инженер	Төв аймаг, Сэргэлэн сум, Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд ажиллах
3	Холбооны хэсгийн мэдээллийн технологийн ээлжийн инженер	Мэдээллийн технологийн сүлжээний инженер	
4	Холбооны хэсгийн радио холбооны ээлжийн инженер	Радио холбооны инженер	
5	Навигацийн хэсгийн навигацийн инженер	Радио холбооны инженер	
6	Ажиглалт, автоматжуулалтын хэсгийн радиолокаторын нөхөн хангалтын ээлжийн инженер	Радио холбооны инженер	Орон нутгийн алслагдсан байгууламжид ажиллах
7	Гэрэл суулт, цахилгааны хэсгийн гэрэл суултын системийн инженер	Цахилгааны инженер	Төв аймаг, Сэргэлэн сум, Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд ажиллах
8	Гэрэл суулт, цахилгааны хэсгийн радиолокаторын цахилгаан тэжээл хариуцсан ээлжийн инженер	Цахилгаан хангамж, автоматикийн инженер	Хөвсгөл аймаг, Түнэл сум, Хэнгэрэгтэй дэх радиолокаторын байгууламжид ажиллах